



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/02

Модот

Өдрийн хоолны нөхөн олговор олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.4. дэх заалт, Монгол Улсын Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 1/554 албан тоотыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус сургуулийн багш, ажилчдад олгох өдрийн хоолны хөнгөлөлтийг 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн ажлын нэг өдөрт 5000 (таван мянга) төгрөгөөр тооцож сар бүр цалингийн зардлаас тооцож олгохыг нягтлан бодогч (Л.Ариунтунгалаг)-т зөвшөөрсүгэй.
2. Багш ажилчдын ажилласан цагийн тооцоог үнэн зөв гаргаж ажиллахыг сургалтын менежер (Д.Ариунаа), нярав (Г.Золбоо) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн (Б.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ